

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХШҮ-НИЙ ТАЙЛАН
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС**

2023 оны 12 дугаар сарын 22

Номгон

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
1	2	3	4	5	6	7	8
1	3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхийг эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	3. Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ	2021 - 2024		Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 50-аас доошгүй ААН-д хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын дэмжлэг үзүүлнэ	Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор Мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг арилжааны 4 банкаар олгож байгаа бөгөөд 21 иргэн, аж ахуй нэгжид 2.01 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгогдох журмын дагуу төслийн сонгон шалгаруулалтыг хийж, 10 ААН 1 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. Тус сангаас бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгосноор орон нутагт шинээр 3 үйлдвэр байгуулагдаж, 6 үйлдвэр үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинээр 20 гаруй ажлын байр нэмэгдэнэ. Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацаар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нийт 647.0 сая төгрөгийн зээлийг 46 иргэн аж ахуй нэгжид олгосон. Зээл олгосноор 34 ажлын байр хадгалагдаж, шинээр 73 ажлыг бий болгоод байна.	100%

2	3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлснээр 100 орчим ажлын байр бий болсон байна.	Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төслийн хүрээнд ХХААХҮЯ-с Сүлжмэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгч сонгон шалгаруулж "ХАШХАН ХХК" 187,300,000 /нэг зуун наян долоон сая гурван зуун мянган/ төгрөгийн өртөгтэй сүлжих машин-2ш, Оёх машин (кеттель)-4ш, Уурын индүү-1ш, Угаалгын машин-1ш, Хатаах машин-1ш, Оймсны машин-1ш, Бээлийний машин-1ш, Дугуй нүхтэй пителийн /товчны нүх/ машин-1ш, Товч хадах машин-1ш нийт 13ш тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр орон нутагт 1 жижиг үйлдвэр нэмэгдэж, 2-3 шинэ ажлын байр нэмэгдэж, сүлжмэл нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлнэ. Тоног төхөөрөмжийг орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломжтой ААН-д журмын дагуу олгохоор судлагдаж байна.	70%
3	3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.	5. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна.	2020 - 2024	18 сум	Баянхонгор аймгийн Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөг "Ланрес" ХХК боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж 2022 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 11/49 дүгээр тогтоолоор батлагдсан.	100%	
4	3.7.9. Хуримтлалын	8. Аймгуудын төвд түрээсийн	2020 - 2024	Түрээсийн орон сууцны	Энэ онд 1187 айлын 25 орон сууцны барилга баригдаж байгаагаас одоогийн байдлаар 429 айлын 9 орон сууцны	70%	

	нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.	орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.			төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	барилга ашиглалтад оруулаад байгаа бөгөөд оны эцэс гэхэд 296 айлын 6 орон сууцны барилга ашиглалтад орно. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр холбогдох асуудлыг аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.	
5	3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	Инженерийн бэлтгэл арга хэмжээний хүрээнд Баянхонгор хотын болзошгүй үер, усны аюулаас сэргийлэх зорилгоор үерийн хамгаалалтын далан байгуулах саналыг БХБ Яаманд хүргүүлсэн бөгөөд 2021 онд зураг төслийн ажлыг боловсруулах зардлыг БХБ Яамнаас 200.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Зураг төсөл боловсруулах аж ахуй нэгжийн сонгон шалгаруулах тендерт “Гидро дизайн инновац” ХХК шалгарч “Баянхонгор хотын төвийн үерийн хамгаалалтын барилга байгууламж, авто замын борооны ус зайлуулах суваг”-ийн ажлын зургийн төслийг боловсруулж 2021 оны 1280/2021 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажуулан 2021 оны 10-р сард ГХБХБ Газарт хүлээлгэн өгсөн. Үерийн хамгаалалтын далан сувгийн угсралтын ажлыг эхлүүлэх талаар 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд БХБ	70%

					Яаманд санал хүргүүлсэн. 2. Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч Г.Энхбаяр, “Годродизайн инноваци” ХХК-ний захирал Г.Батзориг нар 2023 оны 09 сарын 08-ны өдрийн 2023-05 дугаар гэрээгээр Баянхонгор аймгийн Баянхонгор сумын “Шинэ суурьшлын бүс”-ийн үерийн хамгаалалт, зам талбайн ус зайлуулах системийн ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг баталсан. Геодезийн судалгааг “Атар-Од Инженеринг” ХХК, Геологийн судалгааг “Хайлааст Инженеринг” ХХК хийж гүйцэтгэсэн. Шинэ суурьшлын бүсийн Үерийн хамгаалалт, зам талбайн ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төслийн явц 80%-тай явагдаж байна.	
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО						
6	4.3.11. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлэх, гамшгийн үеийн харилцаа холбоог	2. Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.	2021 - 2024	Өмнөговийн Сэврэй, Дорноговийн Сайншанд, Хэнтийн Дархан, Сүхбаатарын Түвшинширээ, Дорнодын Чойбалсан суманд нийт 5 цогцолбор байгуулна.	Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу энэ онд Анхааруулга мэдээг 57 удаа, 2023 оны 3 дугаар сарын 31, 4 дүгээр сарын 08,18, 5 дугаар сарын 14, 17-нд Хүчтэй салхи, цасан болон явган шороон шуурганы Сэрэмжлүүлэг мэдээг Онцгой байдлын газар, сумдын өртөө, харуул, орон нутгийн телевиз, албан байгууллага, аж ахуй нэгж болон ард иргэдэд түргэн шуурхай хүргэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ"-ний 4.3.11.2-т Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолборын байршлыг баталсан. Уг 17 цогцолборт Баянхонгор аймаг хамрагдаагүй тул заалтыг хасуулах саналтай байна.	Хугацаа болоогүй

	сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй бүсүүдэд байгуулна.						
7	4.6.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.	1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах,	2020 - 2024		Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын 22 төлөвлөгөөг хянаж, тодотгол хийгдэнэ.	Цэргийн штабын 2023 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийг гүйцэтгэх үүрэгт нь дадлагажуулах зорилгоор Баянхонгор сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн Хамгаалалтын суман, Дэг журам сахиулахад дэмжлэг үзүүлэх суман, Цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх суман, Гамшиг, хөнөөх хэрэгслийн хөнөөлтэй тэмцэх суман, Эмнэлгийн суман зэрэг сумангуудтай сургалтыг 09 дүгээр сарын 28-ны өдөр шинэ суурьшлын бүсэд цугларалтаар зохион байгуулан явууллаа. Тус	100%

		хяналт тавина.			сургалтад орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн 178 бэлтгэл үүрэгтэн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 46 алба хаагч, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 27 алба хаагч, тусгай зориулалтын 9 нэгж техник, хүн тээврийн 5 нэгж техник хамрагдлаа. Зэвсэгт хүчний 339 дүгээр анги-Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн сургалтаар 3 нэгж техник 12 алба хаагчтай оролцож Цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх суман, Хамгаалалтын суман, Эмнэлгийн сумангуудад дараах 6 хичээлийн цэгүүдийг төхөөрөмжлөн сургалт зохион байгуулсан. Онцгой байдлын газар- 11 алба хаагч, 2 нэгж техник хэрэгсэлтэйгээр Орон нутгийн хамгааллын томилгоот нэгжийн сургалтад хамрагдсан бэлтгэл үүрэгтнүүдэд объектын гал түймэр унтраах, ой хээрийн гал түймэр унтраах, Аюулт үзэгдэл, ослын голомтод нэрвэгдсэн иргэдэд анхны тусламж үзүүлэх, Химийн ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг сэдвүүдийн хүрээнд өртөөчилсөн хэлбэрээр дадлага, сургалтыг чанар, хүртээмжтэй зохион байгуулан ажилласан.	
8		2. Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог бүрдүүлэх, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана.	2020 - 2024	Орон нутгийн цэрэг, томилгоот нэгжийн 22 сургалт зохион байгуулагдана.	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүн, Орон нутгийн цэргийн отрядын бүрэлдэхүүний тодотголыг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн байрлалд 5 дугаар сарын 3-ны өдөр хангайн бүсийн сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай, 11 дүгээр сарын 13,14-ний өдрүүдэд Баянговь, Баянлиг сумдад орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулж тодотгол хийсэн.	100%
9		3. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны	2020 - 2024	Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны	Монгол улсын батлан хамгаалах яам, Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуягын 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 1в/2560 дугаар албан бичгээр ирүүлсэн 79 эксэл файл бүхий судалгааг холбогдох байгууллагуудаас 2019, 2020 оны жилийн эцсийн байдлаарх нийгэм эдийн засгийн үзүүлэлтэд тулгуурлан дайчилгааны	100%

		төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг шинэчилнэ.			төлөвлөгөөний боловсруулалт 50 хувь хийгдэнэ.	төлөвлөгөө боловсруулахад шаардагдах мэдээллийг нэгтгэн 2021 оны 11 дүгээр сарын 19-ны Н/79 тоот албан фичгээр CD-нд хөрвүүлэн файл хэлбэрээр хүргүүлсэн. Мөн “Зэвсэгт хүчний анги, салбаруудыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-г боловсруулан ЗХЖШ-ын даргаар батлуулж Зэвсэгт хүчний Жанжин штабын дайчилгааны хэлтэст хүлээлгэн өгсөн.	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
10	5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	2020 - 2024		Улаанбаатар хот болон төв суурин газрын 2000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна.	Өлзийт суманд 50м3-ийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж, гэр хорооллын 20 айлыг бохирын төвлөрсөн системд холбосон. Мөн энэ онд Галуут, Эрдэнэцогт суманд 50м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Тус цэвэрлэх байгууламж ашиглалтад орсноор гэр хорооллын айл өрхүүдийг нэгдсэн системд холбох боломжтой болно. Баянхонгор сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг “Б софт” ХХК-тай гэрээ байгуулан 2022 онд ажлыг эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд Дулааны шугам 4620м, ариутгах татуурга 17100м, цахилгаан 3800м, холбоо 2070м, халаалтын зуух 2ш 15м*30м хэмжээтэй, ус дулаан дамжуулах төвийн барилга 12м*9м хэмжээтэй, бохир усны насос станцын барилга, дэд өртөөний барилга тус тус хийгдэхээр төлөвлөгдсөн. Тайлант онд Гэгээн шавь 6-р багт 476м дулааны шугам, 5,6-р багийн халаалтын тогооны 15х30м хэмжээтэй ус, дулаан дамжуулах төвийн барилгын суурийн цутгалтын ажил, Дуурсах 3-р багт 604 м дулааны шугамын угсралтын ажил, 1320 м бохирын шугам, 2,7,9 дүгээр багт 2100 м урт цэвэр усны шугам, 3500 м урт бохирын шугамын угсралтын ажил, 4,5-р багт ф200-ийн 420м урттай ширмэн хоолойн угсралт, цэврийн ф75, ф50-ийн HDPE хоолой 1736м, бохирын ф160-ийн давхар эрчлээстэй 1792 м урт хоолойн угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дээрх ажил бүрэн хэрэгжиж дууссанаар Баянхонгор сумын гэр хорооллын айл өрхийн 30 хувь нь инженерийн шугам сүлжээнд холбогдож, нүхэн жорлонгүй	100%

					болно. Мөн энэ онд орон нутгийн хөгжлийн сангийн 180,0 сая төгрөгийн санхүүжилтээр Баянхонгор сумын гэр хорооллын 170 айл, өрхийг стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгосон.	
11	5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2020 - 2024	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон талбайгаас уул уурхай аж ахуйн нэгжүүд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 2021-2022 онд 174,4 га, 2023 онд 43,98 га талбайд нийт 218,38 га талбайд нөхөн сэргээлтийг хийсэн буюу аймгийн хэмжээнд нийт эвдэрч орхигдсон талбайн 30 хувьд нь техникийн нөхөн сэргээлтийг хийсэн үр дүнтэй байна	100%
12	5.1.11. "Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	2. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.	2020 - 2024	Хөв цөөрмийг 3-аас доошгүй газарт шинээр байгуулах, 120-аас доошгүй булаг шандны эхийг хашиж хамгаалсан байна.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Бөмбөгөр сум 2 булаг, Галуут сум 2 булгийн эхийг хашиж хамгаалсан. "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" төслийн хүрээнд зэрлэг ан амьтны усан хангамжийг сайжруулах зорилгоор Баацагаан сумын Шуудуугийн булаг, Баянцагаан сумын Баянбулаг булаг, Шинэжинст сумын Хаяа булгийн эхийг тус тус хашиж хамгаалсан. Ингэснээр энэ онд нийт 7 булгийн эхийг хашиж хамгаалсан. Жаргалант сумын 1 дүгээр багийн нутаг Будын эх гэх газарт янгир ямааны байршил бүхий бүсэд уулын гуу жалгыг ашиглан зэрлэг амьтдыг усаар хангах зорилгоор 20х15 харьцаатай хөв байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" төслийн хүрээнд зэрлэг ан амьтдын ус хангамжийг сайжруулах зорилгоор Баацагаан сумын Товгор багт, Шинэжинст сумын Цагаан сайр нэртэй газар хуучин цооног, Баян-Өндөр сумын Идрэн багт шинээр худаг гарган нарны өргүүртэй болгон тус тус тохижуулсан	100%
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
13	6.2.5. Бүсийн хөгжлийн бодлоготой	1. Бүсийн хөгжлийн бодлоготой	2021 - 2024	Хэрэгжилтийг хангана.	Монгол Улсын Их хурлаас бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоосон татварын шаталсан тогтолцооны нэг нь ААНОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан	100%

	уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.	уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.				татварын хөнгөлөлтүүд юм. Баянхонгор аймаг нь Улаанбаатар хотоос 630 км алслагдсан бөгөөд татвар төлөгчийн гаргасан татварын тайлан, хүсэлтийг үндэслэн жил бүр ААНОАТ-ын тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан татвар төлөгчдөд албан татварын хөнгөлөлт, хуульд заасан буцаан олголтыг олгодог. Татвар төлөгч ААН-үүдийн 2022 оны жилийн эцсийн татварын тайланг үндэслэн Татварын хэлтсийн даргын 2023 оны 03 сарын 09-ний өдрийн А/13 дугаар тушаалаар ААНОАТ-ын тухай хуулийн 22.1 дэх заалтыг үндэслэн 17 ААН-д 2022 оны тайлангаар 143.1 сая төгрөгийн буцаан олголт, ААНОАТ-ын тухай хуулийн 22.5 дахь заалтын дагуу 3 ААН-д 2022 оны тайлангаар 17.2 сая төгрөгийн буцаан олголт, ААНОАТ-ын тухай хуулийн 28.4 дэх заалтын дагуу илүү төлсөн албан татварыг 1 ААН-д 860.9 мянган төгрөгийг буцаан олгохоор тус тус шийдвэрлэсэн. Мөн Татварын хэлтсийн даргын 2023 оны 04 сарын 10-ний өдрийн А/20 дугаар тушаалаар ААНОАТ-ын тухай хуулийн 22.1-д заасны дагуу 17 ААН-д 143.1 сая төгрөгийн хөнгөлөлт, ААНОАТ-ын тухай хуулийн 22.5-д заасны дагуу 4 ААН-д 103.9 сая төгрөгийн хөнгөлөлт, нийт 21 ААН-д 247.0 сая төгрөгийн хөнгөлөлт эдлүүлээ. Баянхонгор аймагт үндсэн болон салбараар бүртгэлтэй томоохон татвар төлөгчид 2023 онд Наранмандал ХХК 1.2 тэрбум төгрөг, Талын торх ХХК 706.5 сая төгрөг, Шаргалжуут рашаан сувилал ХХК 435.6 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.	
14	6.2.8. Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын	1. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрд гэр	2020 - 2024	Гэр хорооллын 3500 өрх инженерийн сүлжээнд холбогдсон байна.	Баянхонгор аймгийн гэр хорооллын бүсийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн боловсруулалтын ажлыг “ДНТ” ХХК гүйцэтгэн, 2021 онд Аймгийн ЗДТГазрын ХОХБТХэлтэс болон ГХБХБГазарт хүлээлгэн өгсөн. 2022 онд гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зарлаж, “Б-СОФТ” ХХК шалгарч 27 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд тайлант онд Гэгээн шавь 6-р багт 476м дулааны шугам, 5,6-р багийн халаалтын тогооны 15х30м хэмжээтэй ус, дулаан дамжуулах төвийн барилгын суурийн цутгалтын ажил, Дуурсах 3-р багт 604 м дулааны шугамын угсралтын ажил,	100%	

	чанарыг дээшлүүлнэ.	хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцөлийг сайжруулна.			1320 м бохирын шугам, 2,7,9 дүгээр багт 2100 м урт цэвэр усны шугам, 3500 м урт бохирын шугамын угсралтын ажил, 4,5-р багт ф200-ийн 420м урттай ширмэн хоолойн угсралт, цэврийн ф75, ф50-ийн HDPE хоолой 1736м, бохирын ф160-ийн давхар эрчлээстэй 1792 м урт хоолойн угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус төслийг ашиглалтад оруулснаар Баянхонгор сумын гэр хорооллын 7 багийн 3000 гаруй өрх инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой болно.	
15	6.2.10. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	1. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	2021 - 2024		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тогтолцоог аймгийн хэмжээнд нэвтрүүлж ажиллаж байна. Энэ онд шинээр 14 сум 94 ширхэг ангилан ялгах хогийн сав байршуулсан. Баян-Өндөр, Баянцагаан, Галуут сумдад хоёрдогч түүхий эд худалдан авч, борлуулдаг иргэд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Өлзийт сум энэ оны 06 дугаар сараас эхлэн сар бүрийн сүүлийн долоо хоногийн Бямба гарагийг дахивар худалдан авдаг өдөр болгож нийт 7000 ширхэг шил, 2,4тн дахивар хогийг цуглуулж “Хонгор дуулим” ХХК-д нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. Баянхонгор сум 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс хог хаягдлыг ангилан ялгаж тээвэрлэж эхэлсэн. Уг ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн 80 орчим хувь нь хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшсэн. Энэ оны гуравдугаар улирлын байдлаар 2844 тн үнс, 12,84 тн хуванцар буюу нийт хог хаягдлын 14,5%-ийг ангилж ялган эдийн засгийн эргэлтэд оруулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 18,0 сая төгрөгийн санхүүжилтээр Эко кэш буюу хуванцар худалдан авдаг автомат машиныг суурилуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд нийтийн гудамж талбай, ил задгай, авто зам дагуу 480 тн, аялал жуулчлалын бүс нутаг дахь уул овоо болон усны сав газарт 137.7 тн, малын сэг зэм 168 тн нийт давхардсан тоогоор 10023 гаруй иргэний оролцоотойгоор 2549 га талбайн 4370 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.	100%

16	6.2.12. Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.	1. Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024		Албаны орон сууцаар хангагдсан байна.	Хүний нөөцийн стратегийн хүрээнд салбарын хэмжээнд 2013-2016 онд “Шинэ зууны эмч”, 2016-2020 онд “Эрүүл мэндийн ажилтны хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж, сумдын эмч нарыг 100 хувь орон сууцаар хангасан. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтаар 83 эмнэлгийн мэргэжилтэнд 603,6 мянган төгрөг, 29.2 дахь заалтаар 16 эмнэлгийн мэргэжилтэнд 484,9 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон. Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 05, 395 дугаар тогтоолуудын хүрээнд салбарын хэмжээнд холбогдох хууль тогтоомжийг үндэслэн 861 албан хаагчид 64,2 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал олгосон байна. Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа албан хаагчдын цалин хөлс өмнөх онтой харьцуулахад 43.1 хувиар нэмэгдсэн байна. Боловсролын салбарт нэн хэрэгцээтэй мэргэжлээр дутагдаж байгаа багш нарыг Баян-овоо, Өлзийт, Шаргалжуут, Баян-Өндөр, Шинэжинст зэрэг хөдөө орон нутагт урьж ажиллуулан, цалингийн нэмэгдэл урамшуулал олгох, амьдрах байраар хангах зэрэг дэмжлэгүүдийг үзүүлж, багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэн сургалтын чанар, үр дүнд анхаарч байна.	100%
17	6.2.13. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг	1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг	2021 - 2024		Ажлын байр нэмэгдсэн байна.	Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах, орон нутгийн түүхий эд нөөц бололцоонд тулгуурлан 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэхээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн үйлдвэрлэл байгуулахаар ажиллаж байна. Ингэний сүүний үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэн үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн угсралт хийгдэж байна. Тус үйлдвэрийн барилгын нийт төсөв нь 3,8 тэрбум бөгөөд 2021 онд холбогдох тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж “Базарь дарь” ХХК шалгарсан. 2021 онд 400 сая, 2022 онд 713.5 сая, 2023 онд 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг	100%

	дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.			олгосон. Мах ногооны зоорь, бойны газар барих төслийн нийт төсөвт өртөг 3 тэрбум төгрөг бөгөөд тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж Сант-Өндөр ХХК шалгарч барилгын ажлыг эхлүүлж, 2021 онд 250 сая, 2023 800 сая төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. Тус мах, ногооны зоорь 2023 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орно.Орон нутгийн түүхий эдийн нөөцийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй 5 ААН байгууллага байна. Түүхий эдийн нөөцийн нэр төрлөөр ангилан авч үзвэл ноолуурын чиглэлээр 3, сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлээр 1, газар тариалангийн чиглэлээр 1 ААН байгаа бөгөөд тайлант онд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн онцлогт тохируулан нийт 55 ажлын байрыг шинээр бий болгосон байна.	
18	6.2.14.. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	2. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	2021 - 2024	Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр 1.2 тэрбум төгрөг батлагдсан. Журмын дагуу төслийн сонгон шалгаруулалтыг хийж, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд 10 ХХК-г уламжилж санхүүжилтээ авсан. Тус сангаас бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгосноор орон нутагт шинээр 3 үйлдвэр байгуулагдаж, 6 үйлдвэр үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинээр 20 гаруй ажлын байр нэмэгдэнэ. Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацаар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нийт 647.0 сая төгрөгийн зээлийг 46 иргэн аж ахуй нэгжид олгосон. Зээл олгосноор 34 ажлын байр хадгалагдаж, шинээр 73 ажлыг бий болгоод байна. Орон нутагт хэрэгжиж буй олон улсын BEST хөтөлбөрөөс 4 иргэн ААН-д 34.4 сая төгрөг олгоод байна. Хоршоог хөгжүүлэх сангаас 49 иргэн аж ахуй нэгжид 852.2 сая төгрөгийн зээлийг олгож хуучин 49 ажлын байрыг хадгалж, шинээр 49 ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. Хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд хөнгөлөлттэй зээлийг арилжааны 4 банкаар дамжуулан 21 иргэн, ААН-д 2 тэрбум төгрөгийн зээлийг олгож, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх боломжоор хангасан байна. Жил бүр уламжлалт болгон зохион байгуулдаг Баянхонгорт-	100%

					Үйлдвэрлэв “Цагаан сар-2023” үзэсгэлэн худалдааг 2023 оны 02 сард, Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааг аймгийн ИТХ-н даргын удирдамжтайгаар, “Баянхонгорын брэнд бүтээгдэхүүн” болзолт уралдааныг шалгаруулалттай хамтатган 2023 оны 09 дүгээр сард буюу орон нутгийн хэмжээнд 2 удаагийн 20 сумын 342 иргэн, ААН оролцсон, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулж, 227.0 сая төгрөгийн худалдан борлуулалт хийсэн байна.	
--	--	--	--	--	--	--